

ХҮННҮГИЙН ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ЗАРИМ ТАМГА ӨНӨӨГИЙН МОНГОЛ АДУУНЫ ТАМГАТАЙ ДАВХЦАЖ БУЙ БАЙДАЛ

Пэрэнлэйлхүндэвийн Гантуяа^{1,*}
Батсуурийн Сувдаа²

¹ Доктор (Ph.D), Монгол улсын их сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн Мэдээлэл компьютерын ухааны тэнхим, Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), Монгол улсын их сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн Мэдээлэл компьютерын ухааны тэнхим, Улаанбаатар, Монгол улс

* Холбоо барих зохиогч: gantuya@seas.num.edu.mn

Хураангуй: Монголчуудын эртний өвөг болох хүннү нарын археологийн олдворууд дээр дүрслэн үлдээсэн дүрс тэмдгүүдийг өнөөгийн урлагийн болон ахуйн хэрэглээнд өвлөн ирсэн байдлыг дэлхий нийтэд сонирхон судалсаар байна. Эрдэмтэн, судлаач, археологичид Хүннүгийн үед тэмдэглэгдсэн дүрс, тэмдэгтийн талаар судалгаа хийж, санал дэвшүүлсэн байдгаас дурдвал Ц.Доржсүрэн, Д.Цэвээндорж, Д.Эрдэнэбаатар, Д.Даваацэрэн нарын зэрэг судлаачид тэмдэгт үсэг болох талаар санал дэвшүүлсэн байдаг бол Ц.Төрбат, З.Батсайхан, Н.Батболд зэрэг судлаачид овгийн угсаа гарлын тэмдэг гэх мэтээр үзсэн байдаг. Тэгвэл бид энэ удаагийн судалгааны ажлаар Хүннүгийн үеийн археологийн олдворууд дээрх зарим дүрс тэмдгийг адууны тамганд хэрхэн давхцаж буй байдлыг харьцуулан судлахаар зорилоо. Хүннүгийн үеийн эдгээр дүрсүүд нь овгийн тамга, хаадын зоосны тамга, эртний үсэг бичгийн дүрстэй холбогдох шинжтэй хэдий ч энэ удаагийн судалгаагаар монгол адууны тамганы хамааралд голлон анхаарч үзлээ. Ингэснээр монголчуудын эртнээс нааш уламжлан ирсэн дүрс тэмдэг, түүгээр дамжсан соёлын залгамжийг таних өөр нэг боломж байж болох талаар, мөн судалгааны эргэлтэд оруулах, өвлүүлэн уламжлуулах, хөгжүүлэх зэрэг ач холбогдолтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: хүннү тамга, монгол адууны тамга

THE SIMILARITY BETWEEN SOME ARCHEOLOGICAL SYMBOLS OF THE HUNNU ERA AND MONGOLIAN HORSE SEALS

Gantuya Perenleikhundev^{1,*}
Suvdaa Batsuuri²

¹ Doctor (Ph.D), Department of Information and Computer Sciences, School of Engineering and Applied Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Department of Information and Computer Sciences, School of Engineering and Applied Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: gantuya@seas.num.edu.mn

Abstract: The world continues to study with great interest how the ancient ancestors of the Mongols, the Huns, have inherited the symbols left on the archeological finds in art and household use. Scholars, researchers, and archaeologists have researched and made suggestions about the images and symbols marked during the Hun dynasty, such as Ts. Dorjsuren, D. Tseveendorj, D. Erdenebaatar, and D. Davaatseren have made suggestions about symbols, while T. Turbat, Researchers such as Z. Batsaikhan and N. Batbold have considered the origin of the clan as a sign of origin. So, in this current research, we aimed to compare and investigate how some of the symbols on the archaeological finds of the Hun period coincide with the horse seals. Although these images of the Hun dynasty are related to tribal seals, royal coin seals, and ancient alphabetic images, this research focuses on the relationship of Mongolian horse seals. In this way, it is considered important to introduce, pass on, and develop research about the symbols that have been handed down by the Mongols since ancient times and the cultural continuity that has passed through them.


Key words: *Xiongnu stamp, Mongolian horse stamp*

Оршил

Төв Азийн цээжинд нүүдэлчдийн анхны төрт улсыг хүннү нар 2231 жилийн өмнө байгуулж, олон үндэстэн улсыг дагуулж, асар уудам газар нутаг бүхий эзэнт гүрнийг бий болгон, 300 илүү жил оршин тогтнож ирсэн түүхтэй. Монголчуудын шууд өвөг болох хүннү нарын талаарх түүх-археологийн судалгаа хийгдэж эхэлснээс хойш даруй 200 гаруй жил өнгөрчээ (Төрбат, Батсүх, Баярхүү, 2012). Хүннүгийн үед хамрагдах тамгатай эд зүйлсийг ангилвал, Чий будагтай аяга, Шавар ваар, Тоосго, Нумын ясан наалт, Дээрийн нүүр ваар, Шагай (Төрбат, Батсүх, Баярхүү, 2012). Олон улсад хийгдсэн дүрс тэмдгийн судалгаа олон байгаа бөгөөд заримаас нь дурдвал, Sergey V. Voroniatov “Connections between central asia and the northern littoral of the black sea: the evidence from objects with tamgas” (2014) сэдэвт ажилд монгол нутгаас олдсон лакан аяганы ёролын тамга, гол мод хоёр булшны олдвор болох шагайн дээрх тамга бусад эдлэл дээрх дүрс, тэмдгийн судалгаа, Helmut Nickel “Tamgas and Runes, Magic Numbers and Magic Symbols” (1973) сэдэвт тамганы дүрсийн судалгааны ажлууд болно.

Судалгааны хэрэглэгдэхүүний хамрах хүрээ

Хүннүгийн тамганы дурсгалыг илэрхийлэх хэд хэдэн чухал олдворууд байна. Үүнд: 1924-1927 онд Ноён ууланд малтсан Хүннүгийн язгууртны булш (Цэвээндорж, Эрдэнэ-Очир, Батболд, Цэнгэл, Алдармөнх, 2008), 2008-2010 онд Ховд аймгийн Үенч сумын нутаг Харгайтын бэлчир, Дунд Жаргалант хэмээх хоёр газраас олдсон тамга, Говь-Алтайн Цагаан гол, Ховдын Ямаан усны олдвор (Төрбат, Батсүх, Баярхүү, 2012), 1955 онд Дорнод аймгийн нутагт Х Пэрлээгийн малтсан Баруун Дөрөөгийн (Барс хот-11) Хүннү хэрмээс олдсон дүрс (Доржсүрэн, 1961), Хүннүгийн язгууртны оршуулга болох Гол мод-2 дурсгалаас илэрсэн малын шагай (Эрдэнэбаатар, Батболд, 2002) зэргээс тогтох Хүннүгийн үед хамрагдах 16 дурсгалын 34 дүрсийг түүвэрлэн авлаа. *Зураг 1*-д зари молдворын зургаас орууллаа (Төрбат, Батсүх, Баярхүү, 2012). Дүрс нэг бүрийн харьцуулалтыг *Хүснэгт 1*-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.



Зураг 1а. Ноён уулын 6-р булшны чий будагтай аяга

б. Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод-2



Зураг 2. Адууны тамганы зарим дүрсээс

Судалгааны арга зүй

Судалгааны ажлын шинжилгээнд урлаг судлалын иконографи (Гантуяа, 2018), иконологи, герменевтик аргуудыг ашиглан анализ синтезийн аргаар дүрсийг задлан шинжилсэн. Судалгаандаа Хүннүгийн үед хамрагдах 16 дурсгалын 34 дүрсийг өнөөгийн монгол малчдын хэрэглэж байгаа 3000 орчим тамганы дүрс (Гантуяа, 2018)-тэй ижил төстэй байдлаар нь харьцуулсан дүн шилжилгээ хийсэн. Тамгануудын гарал үүсэл нэгтэй байдлыг тодорхойлох шалгуурыг С.А. Яценкогийн тодорхойлсон дараах шинжүүдтэй мөн харьцуулсан (С.А. Яценко, 2001). Үүнд:

1. Аль юг талд нь жижиг нэмэлт зураастай (шүлгуул зураас, дэгээ гэх мэт).
2. Нэмэлт геометр дүрс тэй (доор нь юмуу төвд нь нэмсэн дугуй дүрс эсвэл гурвалжин дүрс)
3. Хос тэгш хэмтэй дүрс зураастай
4. Анхдагч дүрсийн толин тусгалыг нэмж дүрсэлсэн
5. Хоёр ижил юмуу өөр тамгыг холбосон байдалтай (тухайлбал, эцэг эхийн овгийн тамгыг холбож зурах).
6. Дөрвөн юмуу гурван ижил тамгыг нэгтгэх зурах зэрэг болно.

Мөн “Адууны тамганы дүрсийг цахим хэлбэрт таниулах арга боловсруулах” сэдэвт докторын судалгааны ажлын хүрээнд боловсруулсан тамганы дүрсийн тайлбар, зохиомж, бэлгэдэл болон жоктол уламжлалд суралцсан тамга унших арга зэрэгт үндэслэн дүрсийн бүтцийг дараах байдалтай ангилал (Гактула, 2018). Үүнд:

1. Дан буюу үндсэн дүрсүүд
2. Хосолмол буюу давхар дүрсүүд (хэд хэдэн дүрсийн нийлэмж)
3. Нэмэлт чимэг дүрсүүд
4. Дүрсийн өндгийн өөрчлөлтөөс нэр өөр болох дүрсүүд
5. Огт хувирадаггүй буюу байр өчлөг нэрээ өөрчлөдөггүй дүрсүүд
6. Нэг ижил дүрсийн өөр өөр нэр

Дээрх хоёр арга аль аль нь дүрсийн холбоо хямаарлыг тогтооход үр дүнтэй гэж үзэн докторын судалгааны ажлын хүрээнд ангилсан тамганы 3000 дүрсийн сэнгэй хармуулалт хийлээ.













Судалгааны үр дүн


Хүснэгт 1 Хүмүүгийн зарим дурсгал дээрх тамганы дүрсийг адууны тамганы дүрстэй харьцуулсан байдал



№	Дурсгалын нэр байршил, м.төрсөн он	Хүснэгт 1-ийн дүрс	Адууны тамганы дүрс	Тайлбар, нэр болон нэмэлт хэсгийн дүрсийн тоо
1	Ноён уулын 23-р булц, 1924-1925 он	Y	Y	Буйн Мал аж ахуйн хэрэгслээр нэригдсэн нэгэн төрөл тамга нь буйн юм. Тэмдгийн хамарт илдэг бурагтаг улдаг мсхыг буйн гэж. Энэ нь хүнийг амьдралд гурам зам бэхдэг гэсэн утганы гүн утганы ойлголттой нийцээтэй тэмдэг. Баруун талын нь булцы, зүүн нь хүнийн, үлдсэн нь ад чөлөөрөө зам хүн өөрөө шийдэж өстөл хэмээдэг. Буйн тамгыг бүтцийн хувьд авч үзвэл 40 гаруй хувилбартай, 11 үндсэн дүрсээс бүтсэн тамга. Чөлөөг дүрсээс ширээ, хүрээ, саргал, хөндөл, сум, мөсдөн зэрэгэр байсан

2	Ноён уулын 6-р булш, 1924-1925 он		Үсэг бичгийн ангилалд орсон нийт дүрсийн бүтцийг авч үзвэл тухайн хэлний гэмдэгт болох нэг үсэг дангаараа тамга болох нь элбэг бөгөөд чимэг дүрсээс сар, хүрээ дүрсийг цөөн тоогоор авсан байна. Олон хувилбар үүсгэсэн нэг хэлбэр нь үсэг хоорондоо хамт орох, болон үг бүтээх зарчмаар бүтсэн байдаг. Нийт тамганы төрөлд үсэг бичгийн тамга 5 орчим хувьтай байна (Гантуяа, 2018).
3	Ноён уулын 6-р булш, 1924-1925 он		Хаадын зоосон дээрх тамга (Нямаа, 2005)  Монгол адууны тамганд бүртгэгдээгүй байна.
4	Симуковын булш, 1927 он		Одоогоор адууны тамганд бүртгэгдээгүй байна.
5	Симуковын булш, 1927 он		Одоогоор яг энэ хэлбэрээр адууны тамганд бүртгэгдээгүй боловч ойролцоо буюу сэрээ тамганы олон хувилбар дүрс хэрэглээнд байна. Дундговь, Өвөрхангай, Увс, Хөвсгөл аймагт голлон бий. Бүтцийн хувьд мухар сэрээ, давхар сэрээ гэсэн үндсэн дүрстэй бөгөөд ширээ, хүрээ, онги, сар, хөндөл, иш зэрэг чимэг зүүлтээр баяжин 40 орчим төрөл бий болгосон (Гантуяа, 2018).


6	Ноён уулын 20-р булш, №59, 2006 он		 	<p>Одоогоор адууны тамганд бүртгэгдээгүй байна. Дүрсийн доод талын дэгээ нь ууль тамга гэж байх бөгөөд судалгааны явцад адууны тамганд орсон эргэсэн хэлбэрийн дүрсийг судлаач Ж.Саруулбуян, А.Давуусамбуу нар “Ууль” буюу шувууны нэр (Саруулбуян, Даваасамбуу, 2013) гээд “Ууль шувууны хошууны тахирыг үлгэрлэн авсан тамганы дүрсийг Уулин тамга гэж нэрлэнэ” хэмээсэн бол, судлаач С.Дулам уг дүрсийг “Уйл” гэж тэмдэглээд үгийн үндсээр нь “гол усны уйл буюу усны тохойн эргүүлгийг хэлж буй бөгөөд түүний эзэн онготой хэмээн төсөөлдөг байсныг гэрчилж байна” (Дулам, 2001) гэжээ. Эндээс үзвэл нэг ижил дүрсийн өөр өөр утга илэрхийлж байгаа нь харагдаж байна. Мөн энэ тамгыг зарим нутагт “гүл шар” (Жүгдэрсүрэн, 2016) гэж нэрлэдэг.</p> <p> Онги, нар гэх мэтээр нэрлэдэг уг дүрсийг хөндөлтэй онги гэж нэрлэж болох бөгөөд төгрөг, дүгрэг гэх мэтээр монголын зарим ястан нэрлэдэг. Жишээ нь, Ховог Сайрын торгууд ястан “төгрөг” хэмээн нэрлэх бөгөөд тэдний үндсэн тамга болдог. Тэгвэл онгин тамга нь Чингис хааны овгийн тамга гэгддэг. Монголчууд XIII зууны үеэс нар сартай тугтай байсан. Онгин нь нар эрхсийн бэлгэдлээс улбаалсан гүн гүнзгий утга агуулгыг илэрхийлдэг. Нарыг дээдлэн эрхэмлэх, тайлга тахилга үйлдэх ёс хүннүгийн үеэс улбаатай. Монголчууд ургах наранд залбирах, наран шүтлэгийн ёс бөөгийн шашны зан үйлд бий. Нар бол монгол домог зүйн бэлгэдэл зүйд өдрийн гэрэл гэгээ, сэрүүн ахуйн аж төрөл эр үүтгэлийн аль алиныг төлөөлж байдаг. Онги болон наран тамгыг ерөнхий дүрсээр нь ижил гэж нэрлэх мэт санагдавч тухайн хоёр ангиллын дүрсийг бүтцийн хувьд нарийн ажиглавал, онгин тамга нэмэлт чимгээр маш баялаг буюу наран тамга нь цацраг голдуу цөөн чимэгтэй байгаа нь анзаарагдана. Тодруулбал, онги тамга ширээ, хүрээ, сар, нүд, гал, хөндөл, туухай, сэнж, эвэр, алх, хумс, сүүд, чойндон, чандмань зэрэг чимгээр баяжин олон хувилбар дүрс үүсгэсэн бол наран тамга хөл, сар, нүд, жинс, цацраг, хүрдийг чимэг болгон авах нь түгээмэл. Дугуй дүрс нь олон утга, нэр, бэлгэдэлтэй болох нь харагдаж байна. Онгин тамганы 116 хувилбар адууны тамганд байна (Гантуяа, 2018).</p>
---	--	--	----------	---

7	Ноён уулын 31-р булш, 2006 он			Одоогоор адууны тамганд бүтэн хэлбэрээр бүртгэгдээгүй байна. Дүрсийн дээд хэсэгт гал тамга, дунд хэсэгт оломтой онги, доод хэсэгт сэрээ тамга дүрсэлсэн байна.
8	Ноён уулын 31-р булш, 2009 он			Одоогоор адууны тамганд бүтэн хэлбэрээр бүртгэгдээгүй байна. Гэхдээ 2 талын дэгрээ зуузай тамга монгол өрхийн тамганд олон хувилбартай байна.
9	Ноён уулын зарим булш			Хос шулуун унжлагатай буйлан тамга. Буйл тамгыг бүтцийн хувьд авч үзвэл, 40 гаруй хувилбартай, 11 үндсэн дүрсээс бүтсэн тамга. Чимэг дүрсээс ширээ, хүрээ, сар, гал, хөндөл, сум, чойндон зэргээр баяжсан. Эдгээр хувилбар монгол өрхийн тамганд олон байна (Гантуяа, 2018).
10	Баруун дөрөөгийн хэрэм			<p> Монгол малчин айл “хотны мал оройтож хээр хоновол хайчны аманд чулуу хавчуулж боох, гэрийн дээвэр цавагны зөрлөгөөр шөвөг хатгадаг нь хайч шөвгөөр чонын амыг дүрслэн тэр шөнө чононд идүүлэхгүй хоног” (Бадамхатан, Цэрэнханд, 2012) гэсэн дүрсийн бэлгэдэл юм. Хэнтий аймгийн Рашаан хаданд хайчин тамганы дүрс бий. Хайчин тамганы 10 гаруй төрөл байх бөгөөд дээш, доош, баруун тийш харсан байхаас гадна амыг нь ангайлгасан болон хаасан хувилбарууд байна. Ширээ чимэг авсан хувилбар ганц байгааг эс тооцвол бараг чимэг дүрс аваагүй болно (Гантуяа, 2018).</p> <p> Халааж юм хайрахад зориулсан зүйл. Хайруул (хайрлага) буюу ташуур тамга гэж нэрлэнэ. Сэцэн хан аймгийн Боржигон сэцэн вангийн хошуунд энэ тамгыг хэрэглэж байв. Энэ тэмдэг нь журам дэглэм, үхэл, эр зориг, сэлэм ба тулааны тэмдэг. Сүхбаатар аймгийн Дарьгангад бий. Одоогоор хайруул тамганы 13 төрөл бий. Хэвтээ, босоо, ташуу гэх зэрэг байх ба хүрээ, сар зэрэг чимэг дүрсээр баяжсан байна (Гантуяа, 2018).</p>
11	Дархан хотын ойрхи Хүннү булш			<p> Монголын ястнууд өөр өөрийн тамга дүрсийг уламжлан авч хэрэглэсээр ирсний нэг жишээ. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Булган суманд хийсэн судалгаагаар нийт 54 төрлийн тамга хэрэглэж байгаагаас 87% нь нуман тамга байгаа нь урианхай ястан эртнээс нуман тамга хэрэглэж байсныг баталж байгаа юм (Гантуяа, 2018).  -ийм дүрс одоогоор адууны тамганд бүртгэгдээгүй байна.</p>

12	Гол мод 2, булш №24			Сэрээ тамганы нэгэн төрөл. Хүснэгтийн 5 дугаар мөрөнд тайлбар орсон.
13	Наймаа толгойн № 6,8,11,14,18			<p>☰ Түшээт хан аймаг Хэбэй амбан бэйсийн хошуунд хэрэглэгдэж байсан тамга (Пэрлээ, 1976).</p> <p>☒ Дотроо чагттай дөрвөлжин тамга. Их хүрээ хавийн Халхын олон хошуудаас ирж суугчдын дунд байв (Дулам, 2001).</p> <p>☒ Руни бичгийн “кь” тамга. ☒ Зөв харсан гох тамга.</p> <p>☒ Ийм дүрс бүхий тамга одоогоор өрхийн тамганд бүртгэгдээгүй байна.</p> <p>☒ Хэвтээ битүү алхан тамга. ☒ Битүү алхан тамга, алхан хээ, хоёр алх зөрүүлэн тавьсан мэт нэг зүйл хээ дан алх, давхар алх. Сүхэн тамга гэж нэрлэж байгаад сүүлд алхан тамга гэж нэрлэсэн. Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай, Увс, Төв аймгийн нутгаар өргөн тархсан. Мянгад ястны үндсэн тамганд ордог (Саруулбуян, Даваасамбуу, 2013).</p>
14	Тэрэлжийн дөрвөлжин, дээврийн нүүр ваар			<p>Одоогоор адууны тамганд бүтэн хэлбэрээр бүртгэгдээгүй байна. Гэхдээ хойд талын дэгрээ зуузай тамга монгол өрхийн тамганд олон хувилбартай байна (Гантуяа, 2018).</p> <p>☒ Ийм дүрс бүхий тамга өрхийн тамганд байхгүй байна.</p>
15	Гол мод-2, булш №3			<p>+ Туухай тамга. Биндэрийн Рашаан хаданд нэмэх тэмдэг хэлбэртэйг эгэл хас буюу тонолт гэж тэмдэглэжээ. /Мал танихуй. Л.Т.2005/ Дундговь, Завхан, Ховд, Өвөрхангай, Хөвсгөл аймагт голлоно. Сараалжин тамга ч гэж нэрлэдэг Мянгадын үндсэн тамганы нэг (Саруулбуян, Даваасамбуу, 2013).</p> <p>* Шагайн дээрх олон чимэгт онгин тамга (Саруулбуян, Даваасамбуу, 2013). нар (онги), алх, сэрээ, дэгрээ тамгадыг нийлүүлэн зохиомжилсон нийлмэл тамга. Өрхийн адууны тамганд эдгээр дүрс дан дангаараа тамга болон хэрэглэгдэж байгаа.</p> <p>☒ Олмон тамга. Хүснэгтийн 17 дугаар мөрөнд тайлбар оруулсан. Ийм ☒, ☒, ☒, ☒, ☒ тамга өрхийн тамганд бүртгэгдээгүй байна.</p>
16	Хар хорум			<p>Одоогоор адууны тамганд бүтэн хэлбэрээр бүртгэгдээгүй байна. Уг дүрсийн хувилбар болох сэрээ тамганы 40 орчим төрөл өрхийн малын тамганд хэрэглэгдэж байна. ☒ Ийм тамга өрхийн тамганд бүртгэгдээгүй байна.</p>

17	Нумын ясан наалт дээр			<p>Олмон тамганы гол эзэд нь баяд үндэстэн гэж нэрлэгддэг бөгөөд баядууд газар нутгийн хэлбэр дүрс хил хязгаарын онцлогийг бататган бэлгэдсэн утгатай. Олмон тамга бүтцийн хувьд 50 гаруй хувилбартай бөгөөд жинс, алх, ааг, буйл зэрэг чимэг зүүлтээр баяжсан байна. Уул дүрс цөөн чимэгтэй байгаа нь баяд ястны эрхэмлэн дээдэлдэг тамга буюу газар нутгийн хил хязгаартай холбоотой хүрээ чимэг аваагүй байж болох юм. Арван баядын хошуунд 14 төрлийн олмон тамга хэрэглэж байсан судалгаа бий (Пэрлээ, 1976).</p>
----	-----------------------	---	---	--

Хүснэгт 1-д нийт 17 дурсгал дээр дүрслэгдсэн 34 тамганы дүрсийг өрхийн адууны тамгатай харьцуулан, үндсэн болон үүсмэл дүрсийн тоо, зарим нэршил, утга бэлгэдэл зэргийг нэмэлт тайлбартайгаар орууллаа.



Зураг 3. Хүннүгийн тамга, өрхийн тамганы харьцуулсан үр дүн

Дээрх *Зураг 3*-г Хүннүгийн олдвор дээрх 34 дүрсийн хэд нь одоогийн өрхийн хэрэглээнд байгаа, хэд нь байхгүй харьцуулан харуулав.

Дүгнэлт

Энэ удаагийн судалгаандаа Хүннүгийн үед хамрагдах 16 олдворын 34 тамга дүрсийг өнөөгийн монгол малчин өрхийг хэрэглээнд байгаа судалгааны явцад бүртгэгдсэн 3000 орчим дүрсийн сантай харьцуулан судалж үзлээ. Нийт 34 дүрсийн 20 нь буюу 58% ямар нэг байдлаар ижил төстэй хувилбар дүрстэй, тэдгээрийг нь одоогийн адууны тамганы дүрсэд хэрэглэдэг, үлдсэн 14 дүрс буюу 42% нь одоогоор малын тамганд бүртгэгдээгүй байна. Мөн ямар нэг байдлаар хувилбар дүрстэй 20 тамганы 11 нь дан буюу үндсэн (анхдагч) дүрс, 4 нь нэмэлт дүрстэй, 2 нь олон өөр

дүрсээс бүтсэн, 3 нь толин байдлаар буулгасан буюу өнцөг өөрчилсөн тамга байна. Эндээс монгол соёлын нэг хэсэг болох тамга тэмдгийн дүрс нь монголчуудын өвөг Хүннү нарын үлдээсэн зарим сурвалжтай хэрхэн адилсаж байгааг харууллаа. Цаашид энэ төрлийн судалгааг итгүү гүнзгийрүүлж, өөр бусад сурвалжтай холбоотой эзэхийг лавшруулж, хиймэл оюун ухааны аргаар дүрсийг таних судалгааны өгөгдөл болгон ашиглаж, үр дүнг харуулах боломжтой гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Бадамхатан, С., Цэрэнханд, Г. 2012. *Монгол улсын угсаатны зүй. (XIX-XX зууны зааг үе). I боть.* Улаанбаатар, Монгол Улс.
2. Гантуяа, П. 2018. “Адууны тамганы дүрсийг цахим хэлбэрт таниулах арга боловсруулах.” Докторын дисертац., Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль.
3. Доржсүрэн, Ц. 1961. *Умард хүннү.* Улаанбаатар, Монгол Улс.
4. Дулам, С. 2001. *Монгол бэлгэдэл зүй. III дэвтэр.* Улаанбаатар, Монгол Улс.
5. Жүтдэрсүрэн, Г. 2016. *Таван эрдэнэ мал сүргээ танихын учир эрдэм.* Улаанбаатар, Монгол Улс.
6. Нямаа, Б. 2005. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын овгийн тамга (XIII-XIV зуун).* Улаанбаатар. Монгол улс.
7. Пэрлээ, Х. 1976. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь.* Улаанбаатар, Монгол Улс.
8. Саруулбуян, Ж., Даваасамбуу, Б. 2013. *Монгол адууны тамганы ойллого.* Улаанбаатар, Монгол Улс: Бэмби сан.
9. Төрбат, Ц., Батсүх, Д., Баярхүү, Н. 2012. *Хүннүгийн Археологийн тамгууд Люаньди Овгийн Тамга болох нь. Археологийн судлал.* Улаанбаатар, Монгол Улс.
10. Цэвээндорж, Эрдэнэ-Очир, Батболд, Цэнгэл, Алдармөнх. 2008. *Ноён уулын хүннүгийн язгууртны 20-р булшны судалгаа. – Талын их эзэнт гүрэн-Хүннү. Монгол-Солонгосын хамтарсан судалгааны 10 жилийн ойн симпозиум.* Seoul: National Museum of Korea.
11. Эрдэнэбаатар, Д., Батболд, Н. 2002 он. “Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт ажилласан Монгол Америкийн хамтарсан Археологийн хээрийн шинжилгээний ангийн тайлан.” АХГБСХ. ХН№1. 2023.
12. Яценко С.А. 2001. *Знаки-тамги ираноязычных народов древности и раннего средневековья.* Москва.
13. Nickel, Helmut. “Tamgas and Runes, Magic Numbers and Magic Symbols.” *Metropolitan Museum Journal* 8 (1973): 165–73. <https://doi.org/10.2307/1512677>.
14. Sergey V. Voroniatov. 2014. “Connections Between Central Asia And The Northern Littoral Of The Black Sea: The Evidence From Objects With Tamgas.” *The Silk Road*, Volume 12: 25-38.